

Гадаадын иргэн, харьяатын газрын даргы
2018 оны 1-дугаар албан бичгийн хавсрал

ГАДААДЫН ИРГЭН ХАРЬЯАТЫН ГАЗАР БОЛОН ХАРЬЯА ГАЗРУУДЫН 2017 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН,
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ЗӨВЛӨМЖИЙН БИЕЛЭЛТ

2018 оны 06 сарын 25

Улаанбаатар хот

№	Байгууллагын нэр	Илэрсэн зөрчил	Аудитаас өгсөн зөвлөмж	Биелэлт	Биелэлт хуви
1	2	3	4	5	6
1	Гадаадын иргэн, харьяатын газар	Зөвлөмж 3.1. Гадаадын иргэн, харьяатын газар 2017 онд батлагдсан үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөг 12.6 сая төгрөгөөр дутуу төвлөрүүлсэн. - Энэ нь 2017 оны Төсвийн тухай хуулиар баталсан үйл ажиллагааны орлогын хуваарийг зөрчсөн.	Орлогын төлөвлөгөөг биелүүлэх, хууль тогтоомжийг мөрдөж ажиллах	2018 оны төсвийн тухай хуулиар батлагдсан 24,0 сая төгрөгийн орлогыг өөрийн орлогоос бүрдүүлэхээр баталсан. 2018 оны эхний хагас жилийн байдлаар 12,0 сая төгрөгийн орлого төвлөрүүлэх төлөвлөгөөтэйгөөс 15,1 сая төгрөгийг төвлөрүүлсэн гүйцэтгэлтэй буюу 125 хувийн давсан биелэлттэй байна. Төлөвлөгөөг 2018 онд 100% биелүүлэх боломжтой.	100
1	Гадаадын иргэн, харьяатын газар	Зөвлөмж 3.2. а) Тайлант онд бараа материалын зардлын данснаас данснаас 26,2 сая төгрөгөөр хөрөнгө бэлтгэж батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулсан байна. б) Гадаадын иргэн, харьяатын газар нь Дорноговь аймаг дахь газрын албан байрнаас Төрийн банканд түрээслүүлсний түрээсийн орлого 27,0 сая төгрөгийг нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлэн засварын материал бэлтгэсэн байна. - Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" 42 дугаар зүйлийн 42.7-д "төсөвт зохицуулалт хийхдээ хөрөнгийн болон урсгал зардлын хооронд нь шилжүүлэх, төсөвт тусгагдаагүй шинэ хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхийг хориглоно" гэж заасныг тус тус зөрчсөн байна.	Үйл ажиллагааны батлагдсан төсөвт зардлыг холбогдох эрх бүхий байгууллага, албан тушаалтны шийдвэргүйгээр бүлэг хооронд шилжүүлэн зарцуулахгүй байх	а) 2018 оны эхний хагас жилийн байдлаар урсгал төсвийн зардлаас хөрөнгө бэлтгээгүй байна. б) 2018 оны эхний хагас жилийн байдлаар түрээсийн болон давсан орлогыг зарцуулсан зарцуулалт хийгдээгүй. Цаашид түрээсийн болон давсан орлогыг зарцуулахдаа Сангийн сайдын 2017 оны 216 дугаар тушаалаар баталсан "Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам"-ын дагуу Сангийн яамнаас зарцуулах эрх авсны дараа зарцуулах төлөвлөгөөтэй байна.	100

1	2	3	4	5	6
2	ГИХГ-ын Хойд бүс дэх газар	Зөвлөмж 3.3. Гадаадын иргэн, харьяатын нормын хувцсыг хүнсний материалын дансанд бүртгэж бараа материалын эдийн засгийн ангиллыг буруу бүртгэсэн байна. Тухайлбал. Тайлант онд Гадаадын иргэн, харьяатын газрын Өмнөд бүс дэх газар нь 26,2 сая төгрөгийн нормын хувцсыг бүртгэлд авахдаа хүнсний материалын зардалд буруу бүртгэсэн байна.	Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, холбогдох журмыг дагаж мөрдөх	Хойд бүс дэх газар, Зүүн бүс дэх газар нь 2014 онд Э-тайланд санхүүгийн тайлангаа шивэхдээ тухайн үед нормын хувцас гэсэн дансны мэдээлэл байхгүй байснаас шалтгаалан Хүнсний материал дансанд буруу бүртгэсэн байсныг Аудитын зөвлөмжийг үндэслэн Сангийн яамны Санхүүжилт тайлан бүртгэлийн хэлтсээс зөвлөсний дагуу 2018 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланг хуулийн хугацаанд 7 дугаар сарын 20-ны дотор Э-тайланд шивэхдээ Хойд бүс дэх газар 879,7 мянган төгрөгийн нормын хувцсыг, Зүүн бүс дэх газар 39,8 сая төгрөгийн нормын хувцсыг тус тус хүнсний материалын данснаас нормын хувцас, зөөлөн эдлэл дансанд шилжүүлэн бүртгэхээр төлөвлөж байна. Тухайн байгууллагуудын санхүүгийн тайланд нормын хувцас, зөөлөн эдлэл дансанд зөв бүртгэлтэй байгаа болно.	100
3	ГИХГ-ын Зүүн бүс дэх газар	- Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д заасан "үнэн зөв байх" Санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал батламж мэдэгдэл. ААНБ санхүүгийн тайланд бүртгэсэн болон түүнийг зохицуулж буй хууль тогтоомжуудтай нийцэж байх гэсэн батламж мэдэгдлүүдийг тус тус хангаагүй байна.	Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, холбогдох журмыг дагаж мөрдөх	Тус газар нь 2018 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн 12/58 тоот албан бичгээр 0.99 төгрөгийн зөрүүтэй биш 0.01 мөнгөөр И-тайланд зөрүүтэй илэрхийлэгдсэн талаар албан бичиг ирүүлсэн. Үүнд үндэслэн Сангийн яамны Санхүүжилт тайлан бүртгэлийн хэлтэст 2018 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн 1-07/1404 тоот албан бичгээр Э-тайланд үндсэн хөрөнгийн элэгдлийн эхний үлдэгдэл 0.01 төгрөгийн зөрүүтэй байгааг засварлуулах тухай хүсэлт хүргүүлсэн. Үйл ажиллагаа засварлах шатандаа явагдаж байна. Тухайн байгууллагын санхүүгийн тайланд зөрүү байхгүй болно.	60
4	ГИХГ-ын Буянт ухаа дахь газар	Зөвлөмж 3.3. Гадаадын иргэн, харьяатын газрын Буянт-Ухаа дахь газрын үндсэн хөрөнгийн элэгдлийн эхний үлдэгдэл 0.99 төгрөгөөр зөрүүтэй илэрхийлэгдсэн байна. - Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д заасан "үнэн зөв байх" Санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал батламж мэдэгдэл ААНБ санхүүгийн тайланд бүртгэсэн болон түүнийг зохицуулж буй хууль тогтоомжуудтай нийцэж байх гэсэн батламж мэдэгдлүүдийг тус тус хангаагүй байна.	Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, холбогдох журмыг дагаж мөрдөх	Тус газар нь 2018 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн 12/58 тоот албан бичгээр 0.99 төгрөгийн зөрүүтэй биш 0.01 мөнгөөр И-тайланд зөрүүтэй илэрхийлэгдсэн талаар албан бичиг ирүүлсэн. Үүнд үндэслэн Сангийн яамны Санхүүжилт тайлан бүртгэлийн хэлтэст 2018 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн 1-07/1404 тоот албан бичгээр Э-тайланд үндсэн хөрөнгийн элэгдлийн эхний үлдэгдэл 0.01 төгрөгийн зөрүүтэй байгааг засварлуулах тухай хүсэлт хүргүүлсэн. Үйл ажиллагаа засварлах шатандаа явагдаж байна. Тухайн байгууллагын санхүүгийн тайланд зөрүү байхгүй болно.	60

ХЯНАСАН:

САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН ДАРГА

ЗӨВЛӨМЖИЙН БИЕЛЭЛТИЙГ ГАРГАСАН:

АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН



Б.ДАВААЖАВ



Б.ЗОЛЗАЯА

